



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/248

Зуунмод

Ажлын хэсэг томилж, зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 61.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 6.5.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалалтын бэлтгэл ажил хангах, агротехнологийн зөвлөмжийг аж ахуйн нэгж, иргэдэд хүргэх, үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийн зөвлөх ажиллуулах зардлыг нэгдүгээр, ажлын хэсэг, сумдад явах маршрут, шаардагдах шатахууны зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Н.Гантулга)-д ДААЛГАХ нь:

2.1. Орон нутгийн онцлог, тариалангийн талбайн угтвар чийгийг үзэж, аж ахуйн нэгж, иргэнд тариалалтад баримтлах технологийн талаар зөвлөгөө өгөх, сумын тариалалтын бэлтгэл ажилтай танилцаж үүрэг чиглэл өгөх, шинэчлэл хийж байгаа үрийг газар дээр нь үзэж хяналт тавих.

2.2. Ажлын хэсгийг 04 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд ажиллуулан тайлан бичиж танилцуулах

3. Ажлын хэсэгт үйлчлэх машин, жолооч, мэргэжилтнүүдийн томилолтын зардлыг Хүнс, хөдөө аж ахуйн газар хариуцан гаргахыг дарга (Н.Гантулга)-д үүрэг болгосугай.

4. Сумдад ажиллах ажлын хэсэгт шаардагдах шатахууны зардлын 4,910,807 (дөрвөн сая есөн зуун арван мянга найман зуун долоо) аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР

